


БАТЛАВ: СУРГАЛТ, ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ **Н.ЭРДЭНЭХҮҮ**



ШУТИС-ИЙН ОЮУТНУУДЫН ШИЛДЭГ ӨГҮҮЛЭЛ ШАЛГАРУУЛАХ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ

НЭГ. Зорилго

Хаврын улиралд бакалаврын оюутнуудын дунд зохион байгуулагдах “Эрдмийн чуулган”-нд амжилттай оролцох оюутнуудын тоог нэмэгдүүлэх, тэдний эрдэм шинжилгээ, судалгааны ажлын ур чадварыг дээшлүүлэх, бүтээлч сэтгэлгээ, багийн ажиллагааг хөгжүүлэх зорилгоор намрын улиралд эрдэм шинжилгээний шилдэг өгүүлэл шалгаруулж цаашид эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны ажлаа улам сайжруулах боломжийг олгох юм.

ХОЁР. Хамрах хүрээ

Их сургуулийн бакалаврын түвшинд суралцагч оюутнууд (гадаад оюутнууд) оролцоно.

ГУРАВ. Хугацаа

Оюутны шилдэг эрдэм шинжилгээний өгүүлэл шалгаруулалтыг 2023 оны 11 дүгээр сарын 24-нд ШУТИС-ийн төв байр, ШУТИС-ийн төв номын санд зохион байгуулна.

ДӨРӨВ. Оюутны эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах шаардлага

1. Асуудлаа тодорхойлсон байдал, хэрэглээ, ач холбогдол
2. Тухайн асуудлыг шийдвэрлэсэн байдал, онцлог шийдэл
3. Техник технологи, эдийн засгийн судалгаа, тооцоолол
4. Оюутны илтгэх ур чадвар
5. Эрдэм шинжилгээний өгүүлэл нь бичлэгийн стандарт шаардлагыг хангасан байдал.

Жич: ШУТИС-ийн эрдэм шинжилгээний өгүүлэл бичих стандартыг баримтална.

Холбоос: https://www.must.edu.mn/mn/esh_oguulel_zavar/

ТАВ. Эрдэм шинжилгээний өгүүллийг шалгаруулах салбар

Салбар 1. Техник, технологи, байгалийн ухаан

Салбар 2. Эдийн засаг, хүмүүнлэг, дизайн

ЗУРГАА. Шалгаруулалт, үе шат

1. Бүрэлдэхүүн сургуулиуд оюутны судалгааны ажил, багш оюутны хамтын ажиллагааг дэмжих байдлаар шилдэг өгүүллийг салбар тус бүрд 3 ба түүнээс дээш тоогоор урьдчилан хэвлэмэл болон файл хэлбэрээр, албан бичгийн хамт 2023 оны 11 дүгээр сарын 08- ний дотор чуулган зохион байгуулах комисст ирүүлнэ. (файл, ppt-г studentservice@must.edu.mn, хэвлэмэл материалыг хичээлийн I байр 327 тоотод).

- II. Оюутны эрдэм шинжилгээний шилдэг өгүүлэл шалгаруулах нэгдсэн хурал 2023 оны 11 дүгээр сарын 24- нд Техник, технологи, байгалийн ухааны салбар хуралдаан хичээлийн I байр “Хурлын танхим”-д, Эдийн засаг, хүмүүнлэг, дизайны салбар хуралдаан ШУТИС-ийн номын сангийн 604 тоот танхимд тус тус зохион байгуулагдана.

ДОЛОО. Шагнал урамшуулал:

Эрдэм шинжилгээний шилдэг өгүүллийг салбар тус бүрд 3 хүртэл байр эзлүүлэн шагнаан урамшуулна.

I байр Батламж, 800.000 төгрөг

II байр Батламж, 500.000 төгрөг

III байр Батламж, 300.000 төгрөг

Оюутны эрдэм шинжилгээний өгүүллийг удирдан ажилласан удирдагч багш нараас шилдэг удирдагч багшийг тус тус шалгаруулан батламж, мөнгөн шагналаар шагнаан урамшуулна.

Оюутнуудын шилдэг эрдэм шинжилгээний өгүүллийг эмхэтгэн хэвлэж хэвлэмэл болон цахим хэлбэрээр нийтийн хүртээл болгоно.

Холбогдох майл хаяг, утас:

Оюутны хөгжил, соёл, үйлчилгээний
алба хичээлийн I байр 327 тоот өрөө
321184, 324590-1035
[/studentservice@must.edu.mn/](mailto:studentservice@must.edu.mn)

ЧУУЛГАН ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС